



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Мандах сумын ерөнхий боловсролын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/102/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуаамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 1-6/165

тантай _____-ны № _____-т

**МАНДАХ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.УНДРАХ-ЭРДЭНЭ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мандах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Мандах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Мандах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 125.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

010000477

Илрүүлэлтээр Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 209.1 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 136.1 сая төгрөгийн 10 гүйлгээг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6.1 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.1 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6.9 сая төгрөгийн 3 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 23 харилцагчдаас 29.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулгаг бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад бараа материалын үлдэгдэл 10.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагад нярав 2 удаа томилогдож, өөрчлөгдсөнөөс няравын сарын ажил тухай бүр хийгдээгүй, хяналт тавиагүйгээс жилийн санхүүгийн тайланг цаг хугацаандаа ирүүлээгүй, хугацаа хоцроосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"; 12.2.2-д эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" хөрөнгийн тооллого хийх заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2 дахь заалт "Төрийн үйлчилгээний албан хаагчид үр чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ." заасны дагуу ажил дүгнэх журам боловсруулаагүй, 2022 оны 4-р улирлын үр чадварын урамшуулал, үр дүнгийн урамшуулал олгохдоо ажлын тайлан бичилт хангалтгүй, сар сараар аваагүй, ажил дүгнэсэн хурлын тэмдэглэл гарын үсэггүй, архив албан хэрэг хөтлөлтийн шаардлага хангаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт"-ын 13.5-д "Анхан шатны

баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно., 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 3 зорилт, 22 арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 87.7 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	55,600,933.06	182,318,006.14
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	124,967,603.08
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	124,967,603.08
3121	Төгрөг	-	124,967,603.08
31211	Төрийн сангийн харилцах	-	124,967,603.08
35	БАРАА МАТЕРИАЛ	55,600,933.06	57,350,403.06
351	Түүхий эд материал	751,000.00	-
35130	Эм боох материал	751,000.00	-
354	Хангамжийн материал	54,849,933.06	57,350,403.06
35410	Бичиг хэргийн материал	3,140,309.00	3,680,189.00
35420	Аж ахуйн материал	31,277,779.06	36,546,379.06
35440	Түлш, шатах тослох материал	11,336,500.00	9,405,000.00
35460	Хүнсний материал	9,095,345.00	7,718,835.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,362,705,876.64	1,617,970,196.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,362,705,876.64	1,617,970,196.50
392	Биет хөрөнгө	1,349,682,459.84	1,605,378,529.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,503,019,947.00	1,822,262,147.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(266,952,327.88)	(312,858,418.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,000,000.00	26,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,000,000.00)	(26,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	133,613,625.26	146,816,625.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(73,737,301.53)	(94,161,583.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,651,917.60	80,651,917.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,958,305.63)	(53,623,363.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,322,480.00	9,322,480.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,241,666.79)	(4,191,666.83)
39217	Ном	10,964,091.81	11,160,391.81
393	Биет бус хөрөнгө	13,023,416.80	12,591,666.88
39301	Програм хангамж	1,857,000.00	1,857,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(849,583.20)	(1,281,333.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,016,000.00	12,016,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,418,306,809.70	1,800,288,202.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,000.00	97,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,000.00	97,400.00
413	Өглөг	2,000.00	97,400.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,000.00	97,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,069,011,855.75	1,800,190,802.64
51	Засгийн газрын хувь оролцоо	1,069,011,855.75	1,800,190,802.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	349,292,953.95
512	Хуримтлагдсан үр дүн	885,055,483.66	1,450,897,848.69
51210	Өмнөх үеийн үр дүн	885,055,483.66	1,084,039,455.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	366,858,392.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	183,956,372.09	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,069,013,855.75	1,800,288,202.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	443,581,896.44	963,429,098.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	326,939,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	326,939,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,005,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,005,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн орлого - Үндсэн хөрөнгө	-	322,962,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн орлого - Бараа материал	-	2,971,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	443,581,896.44	636,489,898.83
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	414,845,200.00	573,326,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	573,326,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	414,845,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,384,573.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,384,573.00	-

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,352,123.44	63,162,998.83
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,352,123.44	63,162,998.83
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	490,955,445.42	596,570,705.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	490,955,445.42	596,570,705.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469,521,093.80	562,128,105.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,123,165.00	337,922,574.22
210101	Үндсэн цалин	235,248,864.00	265,688,295.22
210102	Нэмэгдэл	60,235,735.00	66,638,941.00
210104	Урамшуулал	19,638,566.00	5,595,338.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,872,608.38	45,662,224.70
210201	Тэтгэврийн даатгал	29,357,738.03	31,189,515.24
210202	Тэтгэмжийн даатгал	3,260,105.89	5,046,080.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,510,643.93	3,239,154.98
210204	Ажилгүйдлийн даатгал	504,738.77	559,588.17
210205	Эрүүл мэндийн даатгал	5,239,381.76	5,627,885.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,331,003.44	33,515,683.83
210301	Гэрэл, цахилгаан	1,681,623.44	11,095,333.83
210302	Түлш, халаалт	17,854,380.00	21,523,850.00
210303	Цэвэр, бохир ус	795,000.00	896,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,351,110.70	6,020,720.00
210401	Бичиг хэрэг	1,396,933.00	3,294,320.00
210402	Тээвэр, шатахуун	971,600.00	2,016,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	334,020.00	-
210404	Ном, хэвлэл	902,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	898,750.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,085,660.00	709,890.00
210408	Бараа материал акталсны зардал	1,761,647.70	-
2105	Нормативт зардал	19,017,415.00	41,908,020.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	379,300.00	751,000.00
210502	Хоол, хүнс	18,638,115.00	41,157,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,820,600.00
210604	Урсгал засвар	-	2,820,600.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	-
210702	Дотоод албан томилолт	58,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,097,550.00	3,809,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,294,250.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,809,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,670,241.28	90,469,283.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,609,483.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,610,000.00	724,820.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,060,241.28	80,134,980.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,434,351.62	34,442,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,522,700.00	34,442,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,625,100.00	32,142,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	897,600.00	2,300,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,911,651.62	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,911,651.62	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(47,373,548.98)	366,858,392.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,352,475.85	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,352,475.85	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,352,475.85)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(49,726,024.83)	366,858,392.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	445,000,696.44	652,522,798.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	16,032,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	16,032,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	16,032,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,005,300.00
1200047	шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	15,027,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	445,000,696.44	636,489,898.83

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	414,845,200.00	573,326,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	573,326,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	414,845,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,803,373.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,803,373.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,352,123.44	63,162,998.83
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,352,123.44	63,162,998.83
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	427,967,196.44	515,118,195.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,967,196.44	515,118,195.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,532,844.82	482,079,655.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,606,230.00	339,222,997.30
210101	Үндсэн цалин	225,731,929.00	279,432,293.30
210102	Нэмэгдэл	60,235,735.00	53,373,940.00
210104	Урамшуулал	19,638,566.00	6,416,764.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,872,608.38	43,130,492.62
210201	Тэтгэврийн даатгал	29,357,738.03	28,153,889.17
210202	Тэтгэмжийн даатгал	3,260,105.89	3,653,954.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,510,643.93	4,380,829.21
210204	Ажилгүйдлийн даатгал	504,738.77	626,165.01
210205	Эрүүл мэндийн даатгал	5,239,381.76	6,315,655.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,368,623.44	31,400,833.83
210301	Гэрэл, цахилгаан	1,681,623.44	11,095,333.83
210302	Түлш, халаалт	15,892,000.00	19,415,500.00
210303	Цэвэр, бохир ус	795,000.00	890,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,410,793.00	181,300.00
210401	Бичиг хэрэг	992,573.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	181,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	334,020.00	-
210404	Ном, хэвлэл	902,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,350,250.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,431,450.00	-
2105	Нормативт зардал	26,952,240.00	40,856,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	956,500.00	-
210502	Хоол, хүнс	25,225,990.00	40,856,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	769,750.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,113,500.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	1,113,500.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	-
210702	Дотоод албан томилолт	58,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,747,550.00	5,121,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,944,250.00	907,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,214,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,403,300.00	17,165,832.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,594,932.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,403,300.00	5,570,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,434,351.62	33,038,540.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,522,700.00	33,038,540.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,625,100.00	30,738,540.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	897,600.00	2,300,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,911,651.62	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,911,651.62	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,033,500.00	137,404,603.08
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,033,500.00	12,437,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,033,500.00	12,437,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,033,500.00	12,437,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	12,437,000.00
223001	Бусад хөрөнгө	17,033,500.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(17,033,500.00)	(12,437,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	124,967,603.08
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	124,967,603.08

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,292,953.95	183,902,508.04	901,168,592.59	1,434,364,054.58
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,292,953.95	183,902,508.04	901,168,592.59	1,434,364,054.58
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(16,163,314.68)	(16,163,314.68)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,292,953.95	183,902,508.04	885,055,483.66	1,418,250,945.65
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	349,292,953.95	183,902,508.04	885,055,483.66	1,418,250,945.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	198,983,972.09	198,983,972.09
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,292,953.95	183,956,372.09	1,084,039,455.75	1,617,288,781.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(183,956,372.09)	-	(183,956,372.09)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	366,858,392.94	366,858,392.94
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,292,953.95	-	1,450,897,848.69	1,800,190,802.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	637,968,700.00	527,555,195.75	110,413,504.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,968,700.00	527,555,195.75	110,413,504.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,979,500.00	494,516,655.75	110,462,844.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,948,900.00	339,222,997.30	98,725,902.70
210101	Үндсэн цалин	346,101,500.00	279,432,293.30	66,669,206.70
210102	Нэмэгдэл	82,788,400.00	53,373,940.00	29,414,460.00
210104	Урамшуулал	9,059,000.00	6,416,764.00	2,642,236.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,743,500.00	43,130,492.62	11,613,007.38
210201	Тэтгэврийн даатгал	37,225,600.00	28,153,889.17	9,071,710.83
210202	Тэтгэмжийн даатгал	4,379,500.00	3,653,954.20	725,545.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,503,600.00	4,380,829.21	(877,229.21)
210204	Ажилгүйдлийн даатгал	875,900.00	626,165.01	249,734.99
210205	Эрүүл мэндийн даатгал	8,758,900.00	6,315,655.03	2,443,244.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,009,300.00	31,400,833.83	(1,391,533.83)
210301	Гэрэл, цахилгаан	11,209,300.00	11,095,333.83	113,966.17
210302	Түлш, халаалт	18,000,000.00	19,415,500.00	(1,415,500.00)
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	890,000.00	(90,000.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	-	181,300.00	(181,300.00)
210402	Тээвэр, шатахуун	-	181,300.00	(181,300.00)
2105	Нормативт зардал	40,856,300.00	40,856,300.00	-
210502	Хоол, хүнс	40,856,300.00	40,856,300.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,644,200.00	5,121,900.00	522,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,430,200.00	907,900.00	522,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,214,000.00	4,214,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,777,300.00	29,602,832.00	1,174,468.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,456,400.00	23,281,932.00	1,174,468.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,320,900.00	6,320,900.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,989,200.00	33,038,540.00	(49,340.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,989,200.00	33,038,540.00	(49,340.00)
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,989,200.00	30,738,540.00	2,250,660.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,300,000.00	(2,300,000.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	637,968,700.00	652,522,798.83	(14,554,098.83)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	573,326,900.00	573,326,900.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	573,326,900.00	573,326,900.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,211,600.00	63,162,998.83	48,601.17
132001	Орон нутгийн төсвөөс	63,211,600.00	63,162,998.83	48,601.17
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,430,200.00	16,032,900.00	(14,602,700.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,430,200.00	1,005,300.00	424,900.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		15,027,600.00	(15,027,600.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		124,967,603.08	(124,967,603.08)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33.00	33.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.00	32.00	-
650004	СЕБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	18.00	18.00	-
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	-
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 186.6 сая төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад 186.6 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 184.0 сая төгрөгөөр илүү бүртгэснийг залруулсан.
2. Түрээсийн сурах бичгийн 1.0 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг, тушаасан 0.9 сая төгрөгийг зарлагаар бүртгэснийг, 0.1 сая төгрөг дутуу төлсөнийг өр төлбөр үүсгэж залруулсан.
3. Үндсэн хөрөнгийн 0.02 сая төгрөгийн элэгдлийн /210903/ зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх дансанд /210902/ ангилал сольж бүртгэснийг залруулсан.
4. Үндсэн хөрөнгөд 0.6 сая төгрөгийн хаалга сольсон зардал бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 6 зөрчил² илэрснээс 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 8 дугаар сард үндсэн цалингийн 39 хувиар буюу нийт 0.4 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 559.0 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 349.0 сая төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 64.7 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 40.9 сая төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6.6 сая төгрөгийн 8 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Тус байгууллагад нярав 2 удаа томилогдож, өөрчлөгдсөнөөс няравын сарын ажил тухай бүр хийгдээгүй, хяналт тавиагүйгээс жилийн санхүүгийн тайланг цаг хугацаандаа ирүүлээгүй, хугацаа хоцроосон. Энэ нь хэрэглэгчид үнэн зөв мэдээллээр хангагдаж чадахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж”, Төрийн аудитын тухай хуулийн 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх; гэсэн заалтад нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 23 харилцагчдаас 29.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т “төлбөрийн баримт” гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг”, 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

2. Тооллогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад тусгай зориулалтын материалын үлдэгдэл 10.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь тооллого хийж дууссан огноогоор тооллогын үр дүнг тооцдоггүй, тайлант оны жилийн эцсийн үлдэгдлээр шууд тусгадагтай холбоотойгоор хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг бодитой, чанартай хийж, тооллогын үр дүнгээр холбогдох мэдээллүүдийг тодорхой тусгаж /хэзээ, ямар дансыг, аль өдрийн үлдэгдлээр тоолсон эсэх/ акт үйлдэж байх.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2 дахь заалт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ.” заасны дагуу ажил дүгнэх журам боловсруулаагүй, 2022 оны 4-р улирлын ур чадварын урамшуулал, үр дүнгийн урамшуулал олгохдоо ажлын тайлан бичилт хангалтгүй, сар сараар аваагүй, ажил дүгнэсэн хурлын тэмдэглэл гарын үсэггүй, архив албан хэрэг хөтлөлтийн шаардлага хангаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт”-ын 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно., 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын ажил дүгнэх журмыг боловсруулан, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, үнэн зөв байх, цаг хугацаандаа байх зарчмуудыг мөрдөж гарсан ажил гүйлгээг тухай бүрт нь бодитой бүртгэх

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтүүдийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 184.0 сая төгрөгөөр илүү бүртгэснийг залруулсан.	1	183,956.4		-	1	183,956.4	1	183,956.4		-		
Түрээсийн сурах бичгийн 1.0 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг, тушаасан 0.9 сая төгрөгийг зарлагаар бүртгэснийг, 0.1 сая төгрөг дутуу төлсөнийг өр төлбөр үүсгэж залруулсан.	1	2,010.6			1	2,010.6	1	2,010.6				
Үндсэн хөрөнгийн элэгдлийн /210903/ 0.02 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх дансанд /210902/ бүртгэснийг залруулсан.	1	23.3			1	23.3	1	23.3				
1 ш хаалга сольсон 0.6 сая төгрөгийг үндсэн хөрөнгөд бүртгэснийг зардлаар бүртгэж залруулсан.	1	550.0			1	550.0	1	550.0				
Дүн	4	186,540.3	-	-	4	186,540.3	4	186,540.3	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын тулгалтаар 23 харилцагчдаас 29.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1						1					
Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад тусгай зориулалтын материалын үлдэгдэл 10.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	1						1					
Тус байгууллагад нярав 2 удаа томилогдож, өөрчлөгдсөнөөс няравын сарын ажил тухай бүр хийгдээгүй, хяналт тавиагүйгээс жилийн санхүүгийн тайланг цаг хугацаандаа ирүүлээгүй, хугацаа хоцроосон.	1	-			1	-						

2022 оны 4-р улирлын үр чадварын урамшуулал, үр дүнгийн урамшуулал олгохдоо ажлын тайлан бичилт хангалтгүй, сар сараар аваагүй, ажил дүгнэсэн хурлын тэмдэглэл гарын үсэггүй, архив албан хэрэг хөтлөлтийн шаардлага хангаагүй байна.	1	-				1	-				
Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 8 дугаар сард үндсэн цалингийн 39 хувиар буюу нийт 0.4 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	439.2	1	439.2							
Дүн	5	439.2	1	439.2	1		3				-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Тус байгууллагын шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 559.0 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 349.0 сая төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 64.7 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 40.9 сая төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6.6 сая төгрөгийн 8 шийдвэрийн мэдээллийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-					
Дүн	1		-	-	1	-					